



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 232

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2 дахь хэсгийн 6.2.3, 6.4 дэх хэсгийн 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Дэлгэрхангай сумын соёлын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 11,190,562.00 (арван нэгэн сая нэг зуун ерэн мянга таван зуун жаран хоёр) төгрөгийн балансын үнэтэй, нийт 7,397,279.19 (долоон сая гурван зуун ерэн долоон мянга хоёр зуун далан есөн төгрөг арван есөн ) мөнгөний хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралт дахь хөрөнгийг акталж устгахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Дэлгэрхангай сумын соёлын төвийн эрхлэгч Д.Эрдэнэчулуунд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай. Үүнд:

2.1. Хавсралтад заасан хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 01 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.СҮХБААТАР



0100316

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
 2018 оны 12 сарын 12 -ний өдрийн  
 13 дугаар тогтоолын хавсралт

Дэлгэрхангай сумын соёлын төвийн данснаас хасах үндсэн хөрөнгийн жагсаалт

Д / д	Хөрөнгийн нэр	Ашиглалт анд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуриутлагдсан элэгдэл	Үлдлэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан	Актлах төрөл /1. Устгах 2. Худалдах 3. Сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах 4. Бусад
1	Халаалтын зуух котелийн барилга	2011.12.31	4.4 м2	1	10,872,562.00	10,872,562.00	7,338,979.08	3,533,582.92	Тогоо шатсан, эвдэрсэн	1
2	Нүүрсний агуулах	2015.12.31	11.264 м2		318,000.00	318,000.00	58,300.11	259,699.89	Нуралт өгсөн	1
<b>НИЙТ</b>										
					11,190,562.00 (арван нэгэн сая нэг зуун ерэн мянга таван зуун жаран хоёр)	7,397,279.19 (долоон сая гурван зуун ерэн долоон мянга хоёр зуун далан есөн төгрөг арван есөн мөнгө)	3,793,282.81 (гурван сая долоон зуун ерэн гурван мянга хоёр зуун наян хоёр төгрөг наян нэгэн мөнгө)			